

“НИЙГЭМ ЖУРАМ”-РУУ ЯАРУУЛСАН ЭРХЭМ ЧЕРНОМОРДИК¹ (МОИСЕЙ БОРИСОВИЧ)

Г.Ариунболд*

XX зууны 20-30-аад оны Монгол хийгээд МАХН-ын түүхэнд Монгол дахь Коминтерн хэмээх олон улсын коммунист ажилчны хөдөлгөөний удирдах байгууллагын төлөөлөгч нарын дотроос “ул мөрөө” багагүй үлдээсэн хүмүүсийн нэгэн бол яах аргагүй Черномордик Моисей Борисович юм.

Черномордик 1898 онд Днепропетровск хотноо төрсөн. Еврей гаралтай. Бүх Холбоотын Коммунист (большевик) Намын гишүүн, бага боловсролтой. Коминтерний Гүйцэтгэх Хорооны боловсон хүчний хэлтсийн орлогч эрхлэгчээр ажиллаж байсан байна.



(Арын эгнээнд зүүнээсээ 4 дэх нь Ө.Бадрах, М.Б.Черномордик, Б.Гүнсэн, П.Гэндэн –зох.)

Черномордик нь Москва хотын Горькийн гудамжны 36 дугаар байрны “Люкс” зочид буудлын 125 дугаар өрөөнд амьдарч байх үедээ НКВД-гийнхэнд 1937 оны 6-р сарын 14-нд баривчлагдаж, ЗХУ-ын Дээд Шүүхийн Цэргийн Коллегийн хурлаар орж, 1937 оны 9-р сарын 14-нд цаазаар авахуулсан, түүнийг ЗХУ-ын Дээд Шүүхийн Цэргийн Коллегийн шийдвэрээр 1956 оны 9-р сарын 8-нд цагаатгагджээ.

Коминтерн зүүнтнүүдийн ажлыг удирдуулахын тулд МАХН-ын ТХ-ны хүсэлтээр Черномордикийг томилон илгээсэн ажээ. МАХН-ын ТХ-ны Нарийн бичгийн дарга Золбингийн Шижээ 1937-38 оны үед

* Г.Ариунболд - БХИС-ийн БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

мөрдөн байцаалтад өгсөн өөрийн мэдүүлэгтээ: "...1931 оны зун би Москвагаас Улаанбаатарт ирэх үе дээ анх Черномордиктой танилцсан".

1931 оны эхээр Шижээ Москва орж, намын бага хурлын үр дүнгийн талаар Коминтерний Дорно дахины хэлтэст намын бага хурлын тогтоолууд болон материалуудыг өгч танилцуулан, Сафаров, Мадьяр, Кучумов нарт тайлагнаж, түүнийг нь тэд дэмжжээ. Зүүнтнүүдийн ажлыг удирдуулахаар Черномордикийг МАХН-ын ТХ-нд томилсон гэдэг.

Бас нэгэн байцаалт дээр З.Шижээ хэлэхдээ "...Кучумовоос гадна миний бие троцкист үйл ажиллагааны хүрээнд Коминтерны дорнодын нарийн бичгийн дарга нарын газрын өөр төлөөлөгч, троцкист, Черномордиктой холбоотой байсан.

Асуулт: Та ямар нөхцөл байдалд Черномордиктой танилцсан бэ?

Хариулт: 1931 оны эхээр би Москва руу явж, тэндээс далайн эрэгт амрахаар очсон юм. Энэ удаагийн явалтаар, миний бие, Коминтерны Дорнод Секцид илтгэл тавих үүрэг оногдсон. Би нарийн бичгийн дарга нарын газар илтгэл тавьж, түүн дээр Мадьяр,² Сафаров³ болон Кучумов нар байлцсан. Миний илтгэлийг дэмжиж, Монгол руу удахгүй Коминтерны төлөөлөгч очих болно гэсэн. Би Москвад 20 хоног өнгөрөөж, Кучумовтой уулзалдаж, байсан ба нэг удаагийн ийм уулзалт дээр танихгүй хүн байсан нь, Кучумов надад танилцуулж, энэ бол Черномордик гэсэн.

МАХН-ын ТХ-нд Коминтерны төлөөлөгчөөр очно гэсэн. Энд би анх удаагаа Черномордиктой танилцсан юм. 7-р сард Шижээ Кучумов дээр очиход, тэр Шижээд "...Черномордик бол манай хүн мөн, тэр Кучумовын надад болон манай бүлэгт⁴ даалгасан бүх зүйлийг сайн мэдэж байгаа болно, тийм учир Черномордикийн өгөх бүх үүргийг биелүүлж байхыг зөвлөсөн" гэжээ.

Монголд ирээд, маргааш нь л Шижээ Черномордикийн гэр рүү очсон. Тэр Кучумовоос Шижээг ямар үүрэг даалгавар авсаныг сайн мэдэж байгаа гээд, "...Кучумовын тусгай даалгаврыг намайг санаж байна уу" гэсэн. Шижээ: "санаж байна" гэжээ. Тэр намайг: "сайн байна" гэсэн.

1931 оны хавар бид нугалаа завхралыг бүхий л талаар үргэлжлүүлж байсан...

Мөн нэгэн баримтаас дурьдахад: "...Асуулт: Таны⁵ таньдаг троцкистуудаас хэн нь ЗХУ болон БНМАУ-д удирдах албан тушаал дээрээ хэвээр үлдсэн байна гэв.

Хариулт: Кучумов болон Черномордик нартай миний бие 1936 оноос танил одоо хаана байгааг мэдэхгүй. Монголд өнөөг хүртэл МАХН-ын ТХ-ны нарийн бичгийн дарга Лувсаншарав, Аж Үйлдвэрийн Яамны сайд Дорж, ЗХУ-ын эсрэг үйл ажиллагааг өрнүүлж байна.

Асуулт: Та аль эрт 1932 онд ЗХУ-д ирсэн байж тэдний зөвлөлтийн эсрэг үйл ажиллагааны талаар хаанаас мэдсэн хэрэг вэ?

Хариулт: Доржийн талаар миний бие Бадрахын үгнээс сонсож мэдсэн, 1933 онд Москвад ирсэн Бадрах өөрийн бүлгийнхэнтэйгээ түүний дотор Доржтой харилцаатай хэвээр байгаа. Лувсаншаравтай би, 1935 онд болон 1937 оны намар тааралдаж байсан ба түүнтэй урт удаан хугацаанд илэн далангүй ярилцаж байсан. Би Дотоод Явдлын Яамныханд бүх үнэнийг хэлэхийг хүсэж, хэнийг ч шудрага шүүхээс нуун далдлахыг бодоогүй юм. Би Дотоод Явдлын Яамныханд Лувсаншаравын нэрийг хэлэнгүүт л миний яриаг таслан, камер луу минь аваачсан. Түүнээс хойш ЗХУ-ын төлөөлөгчид бүх үнэнийг хэлэх хүсэлтэй ба Лувсаншаравтай миний хувьд ямар ч хувийн өшөө хонзон байхгүй. /-58-/

Байцаалтыг орос хэл дээр өгсөн. Миний хэлсэн бүхнийг зөв бичсэн байна. Түүний учир гарын үсгээ зурав.

“Шижээ” гэжээ.

“Комисс байнгын дарамтыг Коминтерны зүгээс амсаж байсан бөгөөд феодалуудын өмчийг хураах ажлыг хурдасгахыг нэг бус удаа шахан шаардаж байсан, түүнийг тодорхой хүрээнд хэрэгжүүлэхийг үүрэг болгосон байна. Ийнхүү, ялангуяа, Коминтерний төлөөлөгч Кучумов МАХН-ын ТХ-ны Тэргүүлэгчдийн хуралдаан дээр 1930 оны 6-р сарын 23-нд хэлсэн нь: “...дээд язгууртан феодалуудыг устгах явдал нь ангийн тэмцлийг гүнзгийрүүлнэ. Энэ тэмцлээс айхын шаардлагагүй юм. Тэмцлийг ялалтын эцсийг хүртэл явуулах ёстой”. Үүний дараа Кучумов мөн л Коминтерны төлөөлөгч болох Черномордик нь хүн тус бүрийг дараалан баривчилж, хар, шар феодалуудыг улс орны гадаад байдлыг хурцдуулахгүйн үүднээс шоронд суулгахыг шаардаж байсан ажээ.

Намын анхдугаар бага хурлын дараа хувьсгалын эсэргүү нугалааг гүнзгийрүүлэхэд чиглэгдсэн илтгэлүүдийг танилцуулсан ажээ. Ийм байдлаар хувьсгалын эсэргүү энэхүү байгууллагууд нь харилцан зөрчилдөөнтэй байсан ч гэсэн, нөгөө талаар хувьсгалын эсэргүү нугалаа завхралын тулд зорилготой, нэг л ажлыг хэрэгжүүлж байсан юм.

Тэд хэлбэрийн хувьд л янз бүр болохоос биш, ажил хэргийн хувьд ямар ч ялгаагүй байсан юм.

1931 онд Х.Чойбалсангаар удирдуулсан ойн комисс ардын үндэсний хувьсгалын ойг тэмдэглэж байсан. Х.Чойбалсан ёслолын бүхий л үйл ажиллагаанд биечлэн оролцож, гадаадын зочдыг угтаж, мөн хүлээн авч уулзаж байлаа. Москвагаас ЗСБНХУ-ын Төвийн Гүйцэтгэх Хорооны Тэргүүлэгч гишүүн С.Е.Чуцкаеваар ахлуулсан төлөөлөгчид ирсэн. Ойн комисс ялангуяа, МАХН болон МХЗЭ-ийн түүхэн эмхтгэл хэвлэлд бэлтгэн гаргах үүрэг оногдсон байлаа. Үүнтэй холбогдуулан Х.Чойбалсан монголын үндэсний хувьсгалд оролцсон зөвлөлтийн монголын хувьсгалын үйл хэрэгт гар бие оролцсон зүтгэлтнүүдэд дурсамж, материалууд болон баримт сэлтээ ирүүлэхийг хүссэн юм. Энэ ойн баярыг тохиолдуулан засгийн газар төрийн дээд

шагналуудаар монголын хэсэг иргэдийг шагнасан бөгөөд Х.Чойбалсан хоёр дахь Улаан тугийн одонгоор шагнагдсан юм. Харин улс оронд тэр бүр баярын гэмээр нөхцөл байдал байгаагүй юм. Учир нь Монголд олон талын хямралтай байсан бөгөөд улс төрийн, нийгмийн, эдийн засгийн хямралд орсон байсан. Олонхи нутаг оронд хамтралжуулалттай холбогдсон эсэргүүцэл тэмцэл өрнөсөн, барааны гачигдал, лам нар болон феодалуудыг хөөн дарамталсан гэх зэрэг байдалтай байлаа. Намын удирдлагад З.Шижээ, Ө.Бадрах нарын нэг бүлэг, П.Гэндэн нарын нөгөө бүлэг тус тусдаа үйл ажиллагаагаа явуулж байжээ. Кучумов нар тэргүүтэй Коминтерний Гүйцэтгэх Хорооны төлөөлөгчийн Газрынхан, А.Я.Охтин тэргүүтэй ЗХУ-ын Элчин Төлөөлөгчийн Газрынхан хэмээх хоёр бүлэг мөн хоёр талцан таарамж муутай, эв нэгдэлгүйгээр монголын хэрэгт дур мэдэн оролцож байсан гэлтэй... Монголын П.Гэндэн, З.Шижээ нарын төлөөлөгчдийн Москвад хийсэн айлчлал хүлээсэн үр дүнд хүрээгүй билээ. Коминтерний Гүйцэтгэх Хорооны шийдвэрт тэмдэглэсэнчлэн “баруунтантай” хийсэн тэмцэл, феодалын үлдэгдэлтэй хийсэн тэмцэл, хамтралыг бэхжүүлэх талаар хийсэн тэмцэл, намын эв нэгдлийг хангах талаар хийсэн тэмцэл, улс төрийн дотоод байдлын талаар анхааралтай санаа зовсонгүй гэлтэй ажээ. Монголд мөн үеэр ширүүн үйл явдлууд болж байлаа. Олон аймгуудад олон нийтийн дургүйцэл зэвсэгт бослого болон тэмцэлд шилжиж байлаа. Түүнд олон мянган хүн оролцож, зөвхөн “японы” тагнуулууд төдийгүй /тийм улсууд ч байсан байх - зох./, лам нар болон феодалууд, олон тооны ардууд, хамтралчдын зарим хэсэг, МАХН, МХЗЭ-ийн зарим гишүүдээс үүнд оролцсон байлаа. Босогчдын эсрэг тулалдаанд армийн нэгтгэл ангиуд болон Дотоодын цэргийн анги салбарууд татагдсан байжээ. Босогчдын хөдөлгөөнтэй хийх тэмцэл 1932 оны 10-р сар хүртэл үргэлжилж байна. Олон зуун хүн үхэж үрэгдэжээсэн байна. Улс орон ч ихээхэн хохирол амссан байлаа. 1932 оны 5-р сарын 29-нд Москвагаас Улаанбаатарт МАХН-ын ТХ-ны нэр дээр Коминтерний Гүйцэтгэх Хорооноос болон БХК/б/Н-аас И.В.Сталин, Д.З.Мануильский, О.В.Куусинен нарын гарын үсэгтэй захиаг ирүүлсэн байна. Захидалд: БНМАУ-ын удирдлагын гаргасан “...ноцтой алдаануудын тухай” дурьдагдсан байсан бөгөөд түүнийг хэрхэн арилгах талаар зөвлөлгөө⁶ өгсөн ажээ. 6-р сарын 29-30-нд МАХН-ын ТХ-ны болон Намын Хянан Байцаах Төв Комиссын 3-р онц бүгд хурал хуралдаж, түүн дээр хямралын шалтаг, шалтгаан, мөн түүнээс гарах арга замуудыг хэлэлцсэн байна.

Гэндэн өөрийн илтгэлдээ: “Бослого зөвхөн хувьсгалын эсэргүү ухуулга болон гадаадын дайснуудын дэмжлэгээр болоод зогсохгүй юм. Шалтгаан нь илүү гүн гүнзгий ажээ. Бид бүхэн бүхэл бүтэн ихээхэн алдаа дутагдал гаргасан бөгөөд түүнийг арилгаж засах зайлшгүй

шаардлагатай. Монголын эдийн засаг болон соёлын нөхцөл байдалд, феодалын эсрэг тэмцлийн тухайн үед, үл тохирох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байсан. Феодализмын эсрэг тэмцлийг бид бүхэн бүх нийтийн социалист давшилт болгон өрнүүлсэн билээ.

Бид бүхэн ЗХУ-ыг үлгэрлэн дууриаж байна, гэхдээ манай нөхцөл байдал өөр юм” гэжээ. “Бүгд хурал эрс шийдвэртэйгээр зүүний үйл ажиллагааг шүүмжлэн монголын удирдлагын “шинэ эргэлтийн бодлогыг” тодорхойлсон юм. Бүгд хурал болон түүний дараа залган хуралдсан Улсын Бага Хурлын 17-р чуулганы шийдвэрт хүн амын хувийн аж ахуй эрхлэх санал санаачлагуудыг хөхиүлэн дэмжих, юуны өмнө үндсэн гол салбар болох – мал аж ахуй, хувийн ганзагын, мөн хувийн бараа эргэлтэд дэмжлэг үзүүлэх, шашин шүтэх эрхийг бүрэн хангах гэх мэт арга хэмжээнүүдийн тогтолцоонд гол зүйл болж байлаа. Нам, төрийн удирдлагын шинэ бүрэлдэхүүн сонгогдсон байна. Хэт зүүнтний лидер удирдагчид болох З.Шижээ, Өлзийтийн Бадрах, Л.Лааган болон бусад нөхөд огцорсон ажээ. Улсын Бага Хурлын даргад А.Амар сонгогджээ. Үндэсний нэрт ардчилалч бөгөөд эх орончийн нэр төрийг сэргээн цагаатгажээ. Ерөнхий сайд бөгөөд гадаад Явдлын Яамны сайдад П.Гэндэн томилогджээ. Зүүнтний илэрхий тод нугалаатнуудтай тэмцэж байсан явдал болон нэр нөлөө хийгээд нэр алдарыг нь харгалзан үзсэн байна. ТХ-ны нарийн бичгийн дарга нарын газрын бүрэлдүүнд Б.Элдэв-Очир, Ж.Лхүмбэ, Д.Лувсаншарав нар орсон ажээ. Тэр “зүүнтний” ноёрхлын үед “албан бус удирдагч” нь байсан бөгөөд харин одоо 1932 онд түүний байр суурь хангалттай бэхжсэн юм. П.Гэндэнгийн тэргүүлэх үүрэг төрдөө илэрхий болсон байлаа”.⁷

Хожим хойно З.Шижээг хувьсгалын эсэргүү улс төрийн нууц байгууллагын бослогод бэлтгэж байсан тухай хэрэг гэгч зохиомол асуудалд холбогдуулах үед Коминтерний дорнод хэлтэс дэх троцкист нууц байгууллагын гишүүд болох Кучумов, Черномордик, Полонский, Амагаев нартай шууд холбоотой ажиллаж байсан хэмээн хавтаст хэрэгт нь дурьдсан байх юм.

Золбингийн Шижээгийн мөрдөн байцаалтын баримт дээр дурьдсанаар бол Кучумов нь “...Коминтерны дорнод сектор буюу хэлтэст оршин тогтнож асан троцкист байгууллагын идэвхитэн болох Миф, Черномордик, Полонский, Амагаев нартай холбоотой байсан. Хувьсгалын эсрэг бослогод идэвхитэй бэлтгэж байсан...” хэмээжээ.

Черномордик Шижээд ярихдаа: “Би одоо бүх ажилтай танилцлаа. Энэ хугацаандаа зургаан зүйлийн кампанит ажил зохион байгуулахаар төлөвлөж байна. Үүний тулд л бүрэн эрхт төлөөлөгчдийг илгээсэн бол түүнийг хэрэгжүүлэх шаардлагатай байна. Магадгүй та Кучумовын даалгаврыг мартаагүй биз. Бидний одоогийн зорилт бол үндэсний асуудлуудыг эерэгээр шийдвэрлэх явдал юм. Бид энэ

асуудлуудыг цагаантны үлдэгдлүүд болон түшмэлүүдтэй (чиновник-) тэмцэхгүй бол шийдвэрлэж чадахгүй билээ. Зөвхөн Коминтерний Дорнод хэлтсээс ирэх зааварлагчид л энэ асуудлыг шийдвэрлэж өгч чадна. Эдгээр зааварлагчдыг бид өөрийн талдаа татах хэрэгтэй. Хамгийн гол нь бид цагаантаны үлдэгдлүүдтэй тэмцэх шалтгаар энэхүү асуудлыг шийдвэрлэж болох юм.

Бид Монголд 10 жилийн хугацааны дотор социализмыг ялуулж чадах хэрэгтэй. Бид Пятницкийн⁸ заавар шийдвэрийг практик дээр ойрын хугацаанд гүйцэтгэх шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл Пятницкийгээс намын бага хуралд ирүүлсэн цахилгаан утсанд дурьдсанаар газар тариаланг хөгжүүлэх талаар өгсөн үүргийг хэрэгжүүлж, ЗХУ-аас талх буудай оруулахыг зогсоох хэрэгтэй. Үүний тулд өөрийн талд олон хүмүүсийг хандуулах хэрэгтэй байна” гэжээ.

“...Ийм байдлаар⁹ ...Черномордикоос удирдлага болон зохих зааврыг авсан”. 1931 оны намар Шижээ зааварлагч Парьязевын хамтаар 6 зүйлийн кампанит ажил зохион явуулахаар Дорнод аймгийг зорьсон ба буцаж Улаанбаатарт ирснийхээ дараа өөрийн илтгэлдээ: “Мал бэлтгэл их хэмжээгээр явагдаж байгаа, энэхүү төлөвлөгөө нь ардуудын таварын малын хэмжээнээс хэтэрч байна” хэмээн¹⁰ ...тэмдэглэсэн. Черномордик, Парьязев¹¹ нар Шижээгийн ...яриаг сонсоод энэ бол буруу байр суурь хэмээн дүгнэсэн юм. Черномордик, Парьязев нар “...ийм явдал өөр газарт ч тохиолддог”¹² гээд, иймэрхүү байдалтай тэмцэл явуулах хэрэгтэй гэж зөвлөж байв. Черномордик тухайн үед Улаанбаатарт байсан эрдэмтэн Погральскийн хамт манай малын тоо толгойг тоолоод энэ тооцоог надад үзүүлж, намайг энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэх боломжтойд итгүүл(ж чадсан)-сэн гэжээ.

Тухайн тэр жилийн өвөл явагдсан нугалаа завхралаас шалтгаалан мал бэлтгэлийн төлөвлөгөө арай ядан биелэгдсэн ба дараа жилийн төлөвлөгөөг нь ч өмнөхөөсөө хэд дахин өсгөсөн¹³ байдлаар батлагдсан байна. Үүнээс үзэхэд тухайн цаг үед явагдаж асан нугалаа завхрал гарах гол нөхцөл байдлыг “зүүнтний” гол зөвлөх төдийгүй удирдагч болж асан Черномордик тэргүүтэй Коминтерний төлөөлөгч нар буй болгон зөв чиг шугамаас гаргасан ажээ. Гэхдээ энэ төлөвлөгөө биелээгүй юм. Мал бэлтгэлийн төлөвлөгөөг биелүүлэхэд малын тоо дутсан тул Черномордик, Погральский нар хуурамч тоо нэмж бичээд Коминтернд илгээж байжээ.

ТХ-нд дотоодын хар шар феодалуудтай хэрхэх тухай асуудал хөндөгдөж улмаар хил хязгаар нутгийнхны талаар яригдахад Довчин, Шижээ нарт энэ асуудлаар төлөвлөгөө боловсруулах үүрэг оногджээ. Довчин, Шижээ нар хязгаар нутгийн феодалуудыг улс орны дотоод гүн рүү шилжүүлэн тусгай заасан нутаг оронд нүүлгэх тухай санал гаргасан байна. Энэ төлөвлөгөөг Черномордикт үзүүлсэн боловч үүнийг хэрэгжүүлэхээс түр түдгэлзж, Удалгүй Коминтернээс шинэ заавар авсан

бөгөөд энэхүү зааварт дурьдах даа Монголын гадаад байдал түгшүүртэй байгаатай холбогдуулан хар шар бүх феодалуудыг бүгдийг нь устгах буюу баривчлан, шоронд суулгах шаардлагатай гэжээ. /-34-/

Ийм зааварыг Бичээ, Полонский, Нацов нар болон бусад нь өгсөн ажээ.

Черномордикийн өгсөн үүргийг Банзрагч болон Шижээ нар биелүүлэхийг хичээсэн боловч, Гэндэн, Дэмид нар БНМАУ-ын гадаад байдал түгшүүртэй байгаа тул дотоодын хувьсгалын эсэргүү нарыг түлхэж болохгүй гэж эсрэг байр суурь илэрхийлжээ.

Ингээд 1931 оны сүүлээр Гэндэн, Черномордик нар Москва орж Коминтерний Дорнод хэлтэст илтгэл тавьжээ. /-35-/ Ийнхүү тохиролцсоны дагуу эхлээд байсан хувьсгалын эсэргүү нугалааг гүнзгийрүүлэх хийгээд /нугалааг/ энэ ажлын чиг шугамыг зөв зүйтэй хэмээн үзэж байв.

Шижээ бол илтгэлдээ: удахгүй болох япон-монголын дайны үндэсний мөн чанарыг үгүйсгэн, түүнийг ангийн шинж чанартай дайн хэмээн тооцож сүм хийдийн эсрэг тэмцлийг улам хүчтэй болгох шаардлагатай,¹⁴ өөрөөр хэлбэл ихэнхи нударган нарыг жижиг феодалууд хэмээн үзэж хувьсгалын эсэргүү нугалааг хүчтэй болгохыг эрмэлзсэн хэрэг байв. Черномордик ч мөн ойролцоо утгатай илтгэл тавьсан байна.

Харин Гэндэн өөрийн илтгэлдээ Монголын гадаад улс төрийн байдал түгшүүртэй байгааг харгалзан дотоодын феодал лам нартай хийх тэмцлээ больж, оронд нь нэгдсэн хүчээр гадны дайсантай тэмцэх нь зөв хэмээн үзэж байлаа.

Шижээ хэлэхдээ: "...бидний илтгэлийн товч агуулгыг Черномордик хийж гүйцэтгэсэнээс гадна, түүнийг Гэндэн, Черномордик, Кучумов, Миф, Пятницкий нар хянан тохиолдуулсан байна.

Бидний¹⁵ илтгэлүүдийн дагуу хувьсгалын эсэргүү нугалааны чиг шугамыг баталж, цаашид хэрэгжүүлэх арга замыг тоодорхойлж, үндсэндээ сүм хийдүүдийг бүрмөсөн устгахаар заасан¹⁶ юм. Сүүлийн зорилт шинэхэн байсан юм". Би¹⁷ ирсэн даруйдаа Төв Хороон дээр илтгэлээ танилцуулж, батлуулсан юм. Гэхдээ хэрэгжүүлж чадаагүй билээ..."¹⁸ гэсэн нь буй.

Шижээг Москвад байхад, дээр дурьдсан хувьсгалын эсэргүү хоёр байгууллагын¹⁹ хооронд Бадрах аливаа хөрөнгийг хураан авахын эсрэг зогсож, харин түүнийг байгаа байдлаар нь шилжүүлэн өгөхийн төлөө байр суурь баримталж байсан. Ер нь үнэн хэрэг дээрээ – МАХЦ-т шилжүүлэн өгөхийн төлөө байхад, зарим нэг нь хураан авахын төлөө байр суурь баримталж байв".

Энэ үед Черномордик болон монголын бусад удирдагчид Төв Хорооны орон тоог өөрчлөхийг зорьж, 3 нарийн бичгийн даргаас нэг л Ерөнхий нарийн бичгийн дарга үлдээхийг хүсэж байв. Тэгэхдээ Ерөнхий нарийн бичгийн даргаар З.Шижээг²⁰ үлдээхээр шийдсэн юм.²¹

Гэндэнгийн бүлэг, үүнтэй санал нийлэхгүйн улмаас, өөрийн тэмцлийг улам эрчимжүүлэх болсон.²² Энэ хоёр бүлэг бие биенийгээ хэмлэн дайрах болсон юм.²³ Ингээд аль аль нь тус тусдаа ил тодоор шинэ гишүүн элсүүлж эхэлсэн юм.²⁴

Шижээ 1932 онд Москвад байв. Коминтерны Дорно дахины хэлтэс өөрийн байнгын төлөөлөгчийг дуудахаар шийдэж, МАХН-ын Төв Хорооны бүрэн эрхт төлөөлөгчийг зөвхөн намын их хурлын үеэр л илгээж байхаар болов. Тийм ч учраас Шижээ, Дорно дахины хэлтсээс холбоо барих шифр, зааварчилга, удирдамж авч ирсэн билээ.

Ийнхүү “...дээр хэлснээс үндэс болгон, товчхоноор хэлэхэд, /нөхөд/²⁵ Монголын онцлогт нийцээгүй ажил явуулга хийсэн байх бөгөөд өөрөөр хэлбэл хувьсгалын эсэргүү нугалаа²⁶ явуулсан гэлтэй.

Үүгээрээ З.Шижээгийн хэлсэнээр бол “...улс төрийн бодлогод дайсагнасан төдийгүй, Монголын эрх чөлөөг устгахад хүргэсэн гэлтэй. Би троцкистуудын²⁷ удирдлага дор нугалаа хийсэн байна” хэмээн эндүүрч байсан нь үнэн.

1931 оны татварын бодлого нь үнэхээр сүм хийдүүдийн эсрэг чиглэгдсэн нугалаа хийх зэр зэвсэг нь болсон юм. Сүм хийдэд асар их татвар ноогдсон байна. Гэндэн, Дэмид нар ээлж дараалан Цэцэрлэг аймгийг зорих болж, татварын кампанит ажлыг хэрэгжүүлж иржээ. Ийнхүү, Дэмид нэгэн удаа сүм хийдээс авах татварын ажлаар явах үедээ Банкаас мөнгө зээлдэж, түүнийг эргүүлж өгөхдөө, энэ бол татвараас хураан авсан мөнгө хэмээн /худал/ хэлж өгсөн ажээ. Энэ мэтчилэнгээр “хувьсгалын эсэргүү”²⁸ нугалаа завхралыг хэрэгжүүлэхдээ өрсөлдөн уралдаж ирсэн байна.

Шижээгийн хэлснээр: “...Тэрвээр 1932 оны 8-р сард “Шинэ эргэлтийн бодлого” руу хөтөлсөн намын Онц 3-р Бүгд Хурал дууссаны дараахан Москва хотноо иржээ. Ирсэний дараахан л Коминтерний дорнод хэлтсийн Мадьяр даргатай уулзахад, тэрвээр түүнд: “...Нэгэнт Та Монголд үүрэгт ажлаас зайлуулагдсан тул, ирсэн сургуульдаа орж суралцах явдал чухал билээ. Байдал өөрчлөгдөх байх. Одоохондоо таны хувьд суралцах зорилго шаардлага байна. Черномордиктой ярилц...”²⁹ гэж байжээ.

З.Шижээгийн хэлснээр түүний дараа тэр Черномордиктой очиж уулзсан байна. Тэр Шижээгээс бослогын цар хүрээг лавлаж асуугаад, дараахи зүйлийг хэлжээ.

“Бидний их хэргийг бүтээж хэрэгжүүлэх бодлого амжилтгүй нурсан хэдий ч, миний бие,³⁰ байдал өөрчлөгдөнө хэмээн үзэж буй. Хэрвээ Таныг Монгол руу ямар нэг ажлаар буцаахгүй бол, магадгүй Таныг Шинжаанд³¹ ажиллуулахаар илгээж болох байх. Таны дутагдал гэвэл Та хүн хүчийг дайчлан ашиглаж чадаагүй, өөрийн талд олонхийг татаж, Гэндэнгийн байгууллагыг устгаж, өөрийн гарт оруулж авч чадаагүй явдал юм”³² гэжээ. Тэр З.Шижээг ийнхүү сургаж байв. Энэ ярианы дараа тэд дараагийн уулзалтыг товлож, тохироод салсан байна.

Үүний дараахан мөн оны 10-сард тэр³³ Черномордиктой уулзсан байна. Урьд өмнөх хувьсгалын эсэргүү нугалаа завхралын тухай урт удаан ярианы дараа тэр Шижээгээс асуулт тавьж: “...Шинэ эргэлтийн бодлогыг дэмжиж байна уу гээд шууд хариулахыг хүссэн”. Шижээ гайхашран байгаад самгардаж ямар нэгэн зүйлийг хариу болгон бодож олж чадалгүй, “...МАХН-ын ТХ-ны Онц 3-р бүгд хурал дээр би³⁴ өөрөө өөрийнхөө алдааг ярьж, өөрийгөө буруутай хэмээн хүлээн зөвшөөрсөн шүү дээ...” гэсэн байна. Үүний хариуд Черномордик дараах зүйлийг түүнд хэлсэн.

/-36-/

“Миний бодоход, шинэ эргэлтийн бодлого удаан хугацаанд үргэлжилж чадахгүй³⁵ болов уу. Одоо Таны /З.Шижээгийн-Г.А./ зорилт бол Шинжааныхны амьдрал, зан заншил, ахуй байдлыг судлаж мэдэх явдал, учир нь та эцсийн бүлэгт Шинжаанд³⁶ ажиллах болно гэсэн юм.³⁷ Бид бүхэн таны Шинжаанд очиж ажиллах хүсэлтийг гүйцэлдүүлэх болно гэв. Үүний дараа бид³⁸ хэд хэдэн удаа уулзалдсан юм. Бидний хооронд улс төрийн шинжтэй онцгой гойд яриа болж өнгөрөөгүй бөгөөд тэр намайг ялагдаж буй даа, хэзээ ч гуниж болохгүй хэмээн сургадаг байсан юм...” гэжээ.

“...1934 оны 5-р сарын сүүлчээс Черномордиктой миний харилцаа тасарсан. Миний бие жил хагасын хугацаанд КУТВ дэх Шинжааны оюутны секцэд ажиллаж байсан бөгөөд миний ажлын гол зорилго бол Шинжаантай холбоотой ном, материалуудыг уншин судлах³⁹ явдал байлаа. Би энэ секцийг үгүй болох хүртэл судлахыг хичээсэн билээ. Сурах явцдаа чөлөөт цагаараа оюутны доторхи нийгэм, олон нийтийн ажилд гар бие оролцдог байлаа...” хэмээн З.Шижээгийн хэлсэн нь буй.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Цуврал өгүүлүүд - “Нацов”, “Турар Рыскулов”, “Сэн Катаяма”, “М.И.Амагаев”-ын үргэлжлэл. - Г.А.
2. Коминтерний ажилтан – зох.
3. Коминтерний ажилтан – зох.
4. З.Шижээгийн ахалж байсан МАХН дахь КУТВ-ийнхний бүлэг бололтой – Г.А.
5. З.Шижээгийн – зох.
6. Монголыг байтугай өөрөө өөрсдийгөө зөв зүйтэй удирдаж чадахгүй, бүхэл бүтэн алдаа гаргаж, нугалаа завхралд хүргэж асан “Зүүнтэн” И.В.Сталинаар удирдуулсан БХК/б/Н болон Коминтерний зүгээс БНМАУ-ын удирдагчдад эхлээд буруу зөвлөгөө өгчихөөд, дараа нь гэмээ цайруулахдаа мөн “зөв” зөвлөлгөө өгч чадаж байсан гэдэгт ч эргэлзэхэд хүргэж байсан болов уу гэлтэй. Учир нь Монголын нүүдлийн онцлог аж ахуй, ахуй соёлыг “суурин” орны улс төрийн байр сууринаас

- дүгнэн, удирдаж байсан нь тодорхой байсан болов уу... – Г.А.
7. Рошин С.К., “Монголын Маршал Х.Чойбалсан”., Москва., 2005., 51-52 дахь тал.
 8. Коминтерний Гүйцэтгэх Хорооны гол удирдагч дарга нарын нэг – Г. А.
 9. Шижээ – зох.
 10. Шижээ – зох.
 11. Энэ мэтчилэнгээр “хөдөө”-гийн бүлгийн гишүүд Коминтерныхны болчимгүй санал, шийдвэрийг үг дуугүй гүйцэтгэж, өөрийн байр сууриа илэрхийлэхгүйгээр, үг дуугүй гүйцэтгэгчид болж хувирсан нь эцсийн дүндээ түүхэнд “Зүүнтэний” гэгдэх нугалаа завхрал даамжран гарах урьдчилсан нөхцөл бололцоог бүрдүүлэн өгсөн билээ - зох.
 12. ЗХУ дахь коммун, хамтралжуулалтын түүхэн цаг үед энэ үйл явдал нь мөн адил явагдаж байсан байх юм – зох.
 13. хэд дахин өсгөсөн нь – хэт зүүний үзлийн практик илрэл, үр дүн нь болчихуй – Г.А.
 14. Энэ нь Шижээгийн санаа гэхээсээ илүүтэй, Коминтерны зааварчилгаа байсан гэх нь үнэнд нийцэх буй за – Г.А.
 15. зүүнтэнгүүд – зох.
 16. сүм хийд, лам нарыг устгах төлөвлөгөө аль эрт 30-аад оны эхээр боловсруулагдсан байсан бөгөөд “зүүний” нугалаа гэгдсэн ард түмний бослого хөдөлгөөнийг дарах үед хэсэг хугацаанд хэрэгжилгүй хойшлуулсан нь хожим хойно 1937 онд хэрэгжсэн байна – зох.
 17. Шижээ – зох.
 18. 37 онд л энэ зорилго хэрэгжжээ. Ер нь сүм хийдүүдтэй тэмцэх зорилт нь зөвхөн Сталин болон сталинистуудын хэрэг бус, харин ер нь бүхий л “Коминтерн” болон коммунист хөдөлгөөний эрхэм зорилтуудын нэг болсон байсан бололтой – зох.
 19. Ө.Бадрахын удирдаж асан “зүүний зүүнтэн”, П.Гэндэнгийн удирдсан “зүүний баруунтан” нарын хооронд – зох.
 20. “зүүний нугалаанаас” гарах хор уршиг дан гагц хүнд үлдээж, хариуцлага тооцох бодлоготой байсан хэдий ч, албан тушаалын төлөөх тэмцэл урьдын адил даамжирч, дахин 3 нарийн бичгийн дарга сонгогдсон байх болов уу. - зох.
 21. Энэ нь магадгүй З.Шижээд Коминтернээс даалгасан тусгай үүрэг даалгавартай салшгүй холбоотой байсан болов уу – Г.А.
 22. Үүний цаана мөн Монгол дахь “Коминтерныхан” болон ЗХУ-ын Элчин сайд асан Охтины бүлгийнхний хооронд ширүүн тэмцэл нэгэн адил явагдаж ирсэн бололтой. Энэ тэмцэл нь

- зарим талаараа зарчмын асуудлаар байсан хэдий ч, мөн нөгөөтэйгүүр Ринчино, Рыскулов нарын тэмцлийн нэгэн адил Монгол дахь “Зөвлөлт” оросынхны эрх мэдэл байр суурийн төлөөх тэмцэл байжээ. Энэ бүхэн нь Москвад цэгцрээгүй байсан БХК/б/Н болон Коминтерны бүлгүүдийн хоорондын шууд үр дагавар, тусгал нь болж байсан гэлтэй. – зох.
23. энэхүү бүлэг хоорондын тэмцэл нь нэг талаар “зүүний” нугалааг даамжруулан гүнзгийрүүлэх нэг нөхцөл болсон, нөгөөтэйгүүр мөн хожим хойно гарах 37 оны их хэлмэгдүүлэлтийн уг сурвалж, угтвар болж өгсөн гэлтэй. – зох
24. “зүүний зүүнтэн” “зүүний баруунтан” нар ийнхүү МАХН-д шинээр буй болж, жинхэнэ утгаараа фракцууд буй болж байсан ба нөгөөтэйгүүр энэ бүхэн нь хожим хойно болох “их хэлмэгдүүлэлт”-ийн урьдач нөхцөл болж байсан болов уу. – зох.
25. Шижээ – зох.
26. Энэ бүхэн нь Коминтернээс МАХН-д даалгасан алдаатай бодлого гэхээсээ илүүтэй зарим талаар мөн монголын лам, феодал агсдын тоог цөөрүүлэх нууц, санаатай бодлого байхыг ч үгүйсгэх аргагүй. – зох.
27. Хожим хойно 1937 онд “коминтерн”-ыхныг “сталинист”-ууд “троцкист”-ууд хэмээн цоллон нэрлэж дуудах болсон нь нэг зорилготой байсан хэдий ч, өөрсдийн нэгэн адил түүхэн алдаа буруугаа өөр нэрээр нэрлэн өөрсдөөсөө холдуулах гэсэн бодлого байжээ. – зох.
28. мөрдөн байцаалтанд өгсөн мэдүүлгийн үгээр бол – зох.
29. Мадьяраас эгсүүлээд Золбингийн Шижээг Коминтерн өөрийн удирдлагаар МАХН-ын удирдлагад байх үед буруу зөрүү зааварчилгаагаар толгойг нь эргүүлсэнийхээ хариуд ямар ч хариу барьсангүй, зөнд хаясан бололтой. Ийнхүү Коминтерн З.Шижээгээс эгсүүлээд МАХН-д өөрийн зохион байгуулсан “Хөдөө”-гийн бүлгийн олон олон удирдагчдыг ЗХУ-д улс төрийн шалтгаанаар цөлөгдөх үед нь хүний үнэргүй зөнд нь хаясан байна. Тухайлбал, З.Шижээгийн араас энэ мэтчилэн “Лхүмбэ”-ийн гэгдэх зохиомол хэрэгт мөн Ө.Бадрах, Л.Лааган, Мэнд, Насантогтох, Баттөмөр нарын зэрэг цөөн бус хүмүүс хүрэлцэн очиж, З.Шижээгийн адил хувь тавиланг амссан байна. – Г.А.
30. Черномордик – Г.А.
31. Черномордик нь Шинжаанд болж байсан үндэсний цөөнхийн “хань” угсаатны ноёрхлоос гарах хөдөлгөөнийг удирдаж чиглүүлж байсан бололтой. – зох.
32. Энэ мэт Черномордик нь З.Шижээгийн хувьд өөрийн хийгээд Коминтерний нөхдийн алдаатай буруу заавар

зөвлөлгөөгөө хүлээн зөвшөөрч, уучлалт гуйсангүй, харин эх орноосоо хөөгдсөн хөөрхий улс төрийн цагаачийг тоглон тохуурхах мэт, болчимгүй зөвлөлгөөгөөр ёжлох мэт цэцэрхэн сургамжилсанаас өөр ямар нэгэн тусыг эс үзүүлсэн гэлтэй. Нөгөөтэйгүүр мөн Шижээг Коминтерн Бадрах, Гэндэн нараас илүүд үзэж байсан хийгээд хожим хойно БНМАУ-ын зүй ёсны лидер хэмээн үзэж байсан ч байж болох талтай. Харамсалтай тооцооноос гадуур зэвсэгт хөдөлгөөний үр дагавар өөрсдийнх бэлдсэн гол хүмүүсийг МАХН-ын удирдлагаас зайлуулахад хүргэсэн бололтой – Г.А.

33. З.Шижээ – Г.А.

34. З.Шижээ – Г.А.

35. энэ нь 1937 онд явуулахаар төлөвлөсөн зүйлүүд болон 1936 онд П.Гэндэнг авч хаяхаар төлөвлөсөн зүйлүүдийг хэлж байсан бололтой. Өөрөөр хэлбэл П.Гэндэн болон Гэндэнгийн бодлого, үзэл санаа тэр бүр Коминтернд ч нийцэж байгаагүйг харуулж байна – зох.

36. Ер нь Шинжаан Уйгурын хязгаар нутагт Коминтерн хийгээд ЗХУ-ын нууц төлөөллийн байгууллага үйл ажиллагаагаа өрнүүлж байсан. – Г.А.

37. Коминтерн ийнхүү нэг газраас нөгөөд өөрийн талын хүмүүсийг улс төрийн тагнуулын үүрэг гүйцэтгүүлдэг байлаа. – Г.А.

38. Шижээ, Черномордик нар – зох.

39. Тухайн түүхэн цаг үед хилийн чанадад ажиллаж асан Коминтерний бүх төлөөлөгч, албан хаагч нар ийм ажлыг хийж гүйцэтгэж байсан. – зох.

НОМ ЗҮЙ

1. Стенографический отчет VI Конгресса Коминтерна. // М., 1929, вып.
2. Коммунистический Интернационал в документах. // М., 1933.
3. Черномордик М. К вопросу о коммунистических партиях. // Коммунистический Интернационал. – 1934. - №32/33
4. Люди Коминтерна. // Коммунистический интернационал. – 1935, №7. – С. 4.
5. Дело Золбингийнна Шижээ., Архив ФСБ РФ., Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архив.,
6. Дело Улзийтийна Бадраха., Архив ФСБ РФ.,
7. Пэлжидийн Гэндэнгийн мөрдөн байцаалтын хавтаст хэрэг., Тагнуулын Ерөнхий Газрын Тусгай Архив.,

8. Димитров Георги: Дневник (9 марта 1933 – 6 февраля 1949). // София: Университетско издательство “Св. Климент Охридский”. – 1977. – 794 с.
9. Коминтерн и Вторая Мировая война. Часть I. До 22 июня 1941 г. // М.: Памятники исторической мысли. – 1994. – 555 с.
10. Коминтерн и Вторая Мировая война. Часть II. После 22 июня 1941 г. // М.: Памятники исторической мысли. – 1998. – 596 с.
11. Организационная структура Коминтерна. 1919-1943 гг. // М.: РОССПЭН. – 1997. – 287 с.
12. Коминтерн и идея мировой революции. Документы. // М.: Наука, 1998. – 949 с.
13. Совещания Коминформа. 1947, 1948, 1949. Документы и материалы. // М.: Российская политическая энциклопедия (РОССПЭН), 1998. – 800 с.
14. Пятницкий В.И. Заговор против Сталина. Глава 8: Орготдел – военные работы ИККИ, или Красные волонтеры “невидимого фронта” // М.: Современник, 1998. – 478 с.
15. Коминтерн против фашизма. Документы. // М.: Наука, 1999. – 506 с.
16. Политбюро ЦК РКП(б) - ВКП(б) и Коминтерн. 1919-1943. Документы. // М.: РОССПЭН, 2004. – 960 с.